

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2025 онд 5.5 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбаруудаар авч үзвэл, хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудын үйлдвэрлэл сэргэж, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, байгаль цаг уурын нөхцөл байдал өмнөх жилүүдтэй харьцуулахад таатай байх нөлөөгөөр төл бойжилт өндөр, том малын зүй бус хорогдол бага байж, хөдөө аж ахуй, боловсруулах салбарууд эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх төлөвтэй байна. Мөн уул уурхайн салбарт Оюу толгойн баяжмал дахь зэс, алтны агуулга өсөхөөр байгаа нь салбарын өсөлтөд томоохон нөлөөг үзүүлэхээр байна. Эрэлт талаас хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг үргэлжлүүлэн

дэмжих хүлээлттэй байна. Мал аж ахуйн салбарт эх малын тоо, төл бойжилт нэмэгдэх нөлөөгөөр нийт хөрөнгийн хуримтлал өсөж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Инфляц 2025 онд дунджаар төв банкны зорилтот түвшнээс өндөр байх хүлээлттэй байна. Жил дараалсан хөдөө аж ахуйн салбарын агшилтаас үүдэлтэйгээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөх, цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх төлөвтэй байна. Цаашид геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байна.